

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 7 ДУГААР АНГИЙН МАТЕМАТИК ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

А ХУВИЛБАР

7..... ангийн сурагч овогтой

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ 35 ОНОО

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР Сонгох даалгавар бүр 1 оноотой.

1. Илэрхийллийн утгыг ол.

$$|-3475| - |-2873| + |398| =$$

A. 6746 Б. 1000 В. -204 Г. -1000

2. Илэрхийллийн утгыг ол. $\sqrt[3]{-512}$

А. -8 Б. 8 В. 18 Г. -9

3. 72 ба 99 гэсэн тооны ХИЕХ, ХБЕХ-ийг ол.

A. 9 ба 728 Б. 8 ба 396 В. 9 ба 792 Г. 11 ба 594

4. Пропорцын мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олоорой. $x:12 = 1:4$

A. 5 Б. 1 В. 3 Г. 7

5. Бат санасан тоон дээрээ 212 нэмээд гарсан тооны $\frac{3}{8}$ -ыг олоход 117 гарсан бол

Батын санасан тоог ол.

A. 123 Б. 200 В. 100 Г. 312

6. Аялагч 90км/цагийн хурдтай автобусаар 20 мин явав. Дараа нь мөн тийм хугацаанд 120км/цагийн хурдтай машинаар явжээ. Тэр нийт ямар зам туулсан бэ?

A. 40км Б. 150км В. 70км Г. 210 км

7. Илэрхийллийг хялбарчил. $-8(3c - 6) + 4(7c - 10) - 8$

A. $-4c$ Б. $52c + 40$ В. $4c$ Г. $4c + 10$


$4x^2 - 16x^5 =$ Хаалтнаас ерөнхий үржигдэхүүн гарга.

A. $4x(x - 4x^4)$ Б. $4(x^2 - 4x^5)$ В. $x^2(4 - 4x^3)$ Г. $4x^2(1 - 4x^3)$

9. Утгыг олоорой. $\frac{3^5 * (3^2)^3}{3^9}$

A. 3 Б. 9 В. 3^{21} Г. 3^{16}

10. Зурагт өгсөн тэгш өнцөгт параллелепипедийн эзэлхүүн $6x^2y^3$ бол өндрийг ол.



A. xy^2 Б. $6xy^2$

В. $5xy$ Г. xy


11. 1, 8, 15, 22 дарааллын 15 дугаар гишүүнийг олоорой.

- А. 99 Б. 92 В. 105 Г. 85

12. Гурвалжны өнцгүүд 5 : 6 : 4 харьцаатай бол өнцөг тус бүрийн хэмжээг олоорой.

- А. 50 : 60 : 40 Б. 72 : 48 : 60 В. 48 : 72 : 60 Г. 60 : 72 : 48

13. Мэдэгдэхгүй байгаа өнцгийг ол.



- А. 30°, 150° Б. 42°, 138°
В. 60°, 120° Г. 56°, 124°

14. Хамар өнцгүүд 2 : 3 харьцаатай байв. Эдгээр өнцгүүдийн ялгаварыг ол.

- А. 36 Б. 72 В. 108 Г. 180

15. АВ хэрчмийн дундаж N цэгийн координатыг ол. A(-5,7) ба B(-1, -17)

- А. N(-3, -5) Б. N(-2, 5) В. N(2, -5) Г. N(3, 5)

16. Гурван нугас, дөрвөн галуу нийлээд 2кг 500г, дөрвөн нугас, гурван галуу нийлээд 2кг 400г бол нугас, галуу тус бүрийн жинг ол.

- А. 300, 500 Б. 600, 400 В. 300, 400 Г. 200, 300

17. Өгөгдлүүдийн арифметик дундажийг тооцоолоорой. 1,6,6,8,8,9,11,13,14,17

- А. 7.2 Б. 8.1 В. 6,4 Г. 9.3

18. Гурван зоосон мөнгийг зэрэг орхиход хэдэн ялгаатай үзэгдэл илрэх вэ?

- А. 5 Б. 6 В. 7 Г. 8

19. Гар бөмбөгийн талбайд сууж байгаа 6 тамирчны дундаж өндөр 178 см, сэлгээнд сууж буй 1 тамирчны өндөр 185 см бол баг тамирчдын дундаж өндрийг ол.

- А. 181.5 Б. 179 В. 178 Г. 182

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР


1. Үйлдлийг гүйцэтгээрэй. / 2оноо /

$$\left(7\frac{5}{12} - 5\frac{3}{4}\right) \div 22\frac{1}{2} =$$

2. 1, 6, 11, 16 өгсөн дарааллын дараагийн хоёр гишүүнийг олж, n дүгээр гишүүний томъёог олоорой. / 2 оноо /

3. 25 см урттай лаг асаагаад 12мин болсны дараа 20см урттай болжээ. Тэгвэл бүтэн лаа ямар хугацаанд асаж дуусах вэ? / 3 оноо /

4. Призмийн гадаргуугийн талбайг олоорой. / 3 оноо /



5. Дөрвөн хүүхэд дугаарлан зогсов. Болд хамгийн ард зогсохгүй байх үзэгдлийн эсрэг үзэгдлийг нэрлэж, магадлалыг олоорой. / 3 оноо /

6. Гүдгэр дөрвөн өнцөгтийн эсрэг орших хоёр өнцгийн нийлбэр 180° ба харьцаа нь 5:4 байв. Хэрэв үлдсэн хоёр өнцгийн харьцаа 7 : 2 бол дөрвөн өнцөгтийн дотоод өнцгүүдийг тооцоол. / 3 оноо /

**2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 7 ДУГААР АНГИЙН МАТЕМАТИК ХИЧЭЭЛИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ**

Б ХУВИЛБАР

7..... ангийн сурагч овогтой

ХУГАЦАА 60 МИНУТ

НИЙТ 35 ОНОО

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР Сонгох даалгавар бүр 1 оноотой.

1. Илэрхийллийн утгыг ол.

$$|-3922| - |3265| + |-137| =$$

A. 7050 Б. 794 В. 520 Г. -794

2. Илэрхийллийн утгыг ол.

$$\sqrt[3]{-729}$$

А. -8 Б. 9 В. 18 Г. -9

3. 42 ба 51 тооны ХИЕХ, ХБЕХ-ийг ол.

A. 3 ба 2142 Б. 3 ба 714 В. 7 ба 714 Г. 3, 17

4. Пропорцын мэдэгдэхгүй байгаа гишүүнийг олоорой. $x:18=1:6$

A. 5 Б. 1 В. 3 Г. 7

5. Бат санасан тоон дээрээ 271 нэмээд гарсан тооны $\frac{2}{7}$ -ыг олоход 126 гарсан бол Батын санасан тоог ол.

A. 123 Б. 170 В. 150 Г. 312

6. Аялагч 60 км/цагийн хурдтай автобусаар 120 мин явав. Дараа нь мөн тийм хугацаанд 70 км/цагийн хурдтай машинаар явжээ. Тэр нийт ямар зам туулсан бэ?

A. 200км Б. 180км В. 260 км Г. 210 кмц

7. Илэрхийллийг хялбарчил. $9y - 5(2y - 7) - 25$

A. $-y + 10$ Б. $y + 10$ В. $19y + 10$ Г. $y - 10$


8. $3xy^2 - 9x^2y =$ Хаалтнаас ерөнхий үржигдэхүүн гарга.

A. $3xy(x - 4y)$ Б. $6(y - 3x)$ В. $x^2(4 - 4x^3)$ Г. $3xy(y - 3x)$

9. Утгыг олоорой. $\frac{3^{12} * (3^3)^4}{3^7}$

A. 3^{17} Б. 9 В. 3^{21} Г. 3^{16}

10. Зурагт өгсөн тэгш өнцөгт параллелепипедийн эзэлхүүн $18x^2y^3$ бол өндрийг ол.




A. xy^2

Б. $9xy^2$

В. $6xy$

Г. $2xy$

11. 2, 11, 20, 29 дарааллын 12 дугаар гишүүнийг




A. 96 Б. 104 В. 112 Г. 96

12. Гурвалжны өнцгүүд 4 : 7 : 7 харьцаатай бол өнцөг тус бүрийн хэмжээг олоорой.

A. 40 : 70 : 70 Б. 70 : 40 : 60 В. 70 : 70 : 40 Г. 60 : 60 : 60

13. Мэдэгдэхгүй байгаа өнцгийг ол.



A. $76^\circ, 104^\circ$

Б. $42^\circ, 138^\circ$

В. $52^\circ, 128^\circ$

Г. $56^\circ, 124^\circ$

14. Хамар өнцгүүд 6 : 3 харьцаатай байв. Эдгээр өнцгүүдийн ялгаварыг ол.

A. 120 Б. 60 В. 90 Г. 180

15. АВ хэрчмийн дундаж N цэгийн координатыг ол. A(-6,9) ба B(2,3)

A. N(-3,6) Б. N(-2,6) В. N(3,-6) Г. N(-3,-6)

16. Хоёр туулай, гурван үнэг нийлээд 7кг 600г, гурван туулай, хоёр үнэг нийлээд 6кг 400г бол туулай, үнэг тус бүрийн жинг ол.

A. 800, 2000 Б. 600, 2100 В. 500, 2400 Г. 200, 3000

17. Дундажууд гэж юу вэ?

A. Моод, медиан, далайц Б. Арифметик дундаж
В. Моод, медиан, арифметик дундаж Г. Арифметик дундаж, далайц, моод

18. Өгөгдлүүдийн арифметик дундажийг тооцоолоорой. 6,7,7,9,9,9,11,11,14,17

A. 8.3 Б. 8.9 В. 10 Г. 9.4

19. 100-аас ихгүй натурал тоог санамсаргүйгээр бичихэд тэр тоо нь 10-т хуваагддаг байх үзэгдлийн эсрэг үзэгдлийн магадлалыг олоорой.

A. 10 Б. 0.9 В. 0.1 Г. 1

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР


1. Үйлдлийг гүйцэтгээрэй. / 2оноо/

$$2.88 * \frac{35}{72} + \left(1.0625 - \frac{5}{12}\right) * 16 =$$

2. 2.Тахиа туулай нийлээд 49, тэдний хөл нь яг 100 байв. Хэдэн тахиа, туулай байгааг зөрөөгөөр тооцоолох болон тэгшитгэл зохиох аргаар олоорой. /3 оноо /

3. 3.Өгсөн дарааллын дараагийн хоёр гишүүнийг ол. n -р гишүүний томьёо бичээрэй.
/ 2 оноо /
2, 10, 18, 26

4. Призмийн гадаргуугийн талбайг олоорой. / 3 оноо /



5. Гүдгэр дөрвөн өнцөгтийн эсрэг орших хоёр өнцгийн нийлбэр 180° ба харьцаа нь 2:4 байв. Хэрэв үлдсэн хоёр өнцгийн харьцаа 5 : 4 бол дөрвөн өнцөгтийн дотоод өнцгүүдийг тооцоол. / 3 оноо /

6. 6.100-аас бага хоёр оронтой тоо таамгаар сонгоход тэр нь 5 ба 9-ын ядаж нэгэнд нь хуваагдах үзэгдлийн магадлалыг олоорой. Энэ үзэгдлийн эсрэг үзэгдлийг нэрлэж, магадлалыг нь олоорой. / 3 оноо /

